

ТЕНДЕРИЙН УРИЛГА

Огноо : 2020 оны 04 дүгээр сарын 02-ны өдөр
Тендер шалгаруулалтын нэр: **ЖССҮ-2 автоашигчийн их засварт шаардлагатай сэлбэг**
Тендер шалгаруулалтын дугаар: **МРЦМ/202012089**

“Монголросцветмет” ТӨҮГ эрх бүхий тендерт оролцогчдоос **ЖССҮ-2 автоашигчийн их засварт шаардлагатай сэлбэг** нийлүүлэх тухай битүүмжилсэн тендер ирүүлэхийг урьж байна.

Тендерийн баримт бичгийг иж бүрдэлээр нь **50,000.00 /тавин мянган/** төгрөг, эсхүл түүнтэй тэнцэх хэмжээний чөлөөтэй хөрвөх валютаар худалдан авч болно. Тендер нь түүнийг нээсэн өдрөөс эхлэн **30** хоногийн дотор хүчинтэй байна.

Тендерт оролцогч нь Санхүүгийн болон туршлагын дараах шаардлагыг хангасан байна.

Үүнд:

Борлуулалтын хэмжээ: **Сүүлийн 2 жил буюу 2018, 2019 оны аль нэгд гүйцэтгэсэн борлуулалтын хэмжээ тендерийн үнийн саналын мөнгөн дүнгийн 100%-иас багагүй байна.**

Түргэн хөрвөх чадвартай хөрөнгө болон авах боломжтой зээлийн хэмжээ: **Тендерт ирүүлсэн үнийн саналын мөнгөн дүнгийн 100 хувиас багагүй байна.**

Тендерийн хамт **6,900,000** төгрөгийн дүнтэй тендерийн баталгаа ирүүлнэ.

Тендерийг **2020 оны 05 дугаар сарын 06-ний өдрийн Цаг: 09:00 цагаас өмнө www.tender.gov.mn хаягаар ирүүлэх ба мөн өдрийн 09:10 цагт цахим системээр нээнэ.**

Гадаадын этгээд тендер ирүүлэх эрхтэй, эрхгүй эсэх: **Зөвшөөрнө.**

Дотоодын давуу эрх тооцох эсэх. **Тооцохгүй.**

Сонирхсон этгээд тендерийн баримт бичигтэй холбоотой болон бусад мэдээллийг доорх хаягаар авч болно.

Улаанбаатар хот, БЗД 22-р хороо, Энхтайваны өргөн чөлөө – 98, 505 тоот өрөө, утас: 450060 + 180

“МОНГОЛРОСЦВЕТМЕТ” ТӨҮГ